



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2018.04.03 № 19

**Асуулга тавих тухай**

Манай Улсын эдийн засгийн гол тулгуур болсон мал аж ахуй болон газар тариалангийн салбарыг төрөөс зайлшгүй анхаарч, хууль эрх зүйн орчныг ойлгомжтой тодорхой болгох, шаардлагатай шийдвэрийг цаг алдалгүй гаргаж байх нь төрийн үүрэг юм.

Сүүлийн жилүүдэд мал сүргийн тоо толгой эрс өсч, 2017 оны байдлаар 66,2 сая хүрсэн хэдий ч малын гаралтай түүхий эд, түүнийг эцсийн бүтээгдэхүүн болгох, экспортод гаргах чиглэлээр дорвитой ажил хийхгүй байна. Мөн өнгөрсөн зун тариалангийн ихэнх бүс нутгаар хур тунадас багатай, зарим бүс нутгуудад огт хур тунадас ороогүй, нарны хэт их халалт болсны улмаас бүх бүс нутгуудад тариалагдсан таримлын өсөлт хөгжилт саарч, нэгжээс хураан авах ургацын хэмжээ буурсан зэрэг олон асуудал гарсан.

2018 он гарснаас хойш шатахуун, түлшний үнэ литр тутамд 200-370 төгрөгөөр нэмэгдсэн нь ард, иргэдийн бухимдлыг төрүүлээд зогсохгүй, мал аж ахуй болон үр тарианы үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүд, малчид, тариаланчдад хүндээр тусахаар байна.

Иймд улс даяар хаврын их ажил эхлэх гэж буйтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Малын зүй бус хорогдлоос урьдчилан сэргийлэх, малын гоц халдварт шүлхий өвчинтэй хэрхэн тэмцэх, хохирлыг хэрхэн барагдуулах, мал төллөлтийн өнөөгийн нөхцөл байдал, хичнээн төл авах урьдчилсан тооцоо болон хаврын мал төллөлттэй холбогдуулан малчдад ямар дэмжлэг үзүүлж байгаа талаар,
2. Улсын хэмжээнд үр тарианы тариалалтад зориулж шатахууны нөөц болон үрийн нөөц бэлэн эсэх талаар,
3. Шатахуун, түлшний үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан хаврын тариалалтад Монгол Улсын Засгийн газраас ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа талаар,

4. Хаврын тариалалт эхлэх гэж байгаатай холбогдуулан тариаланчдыг хэрхэн дэмжих, намар хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхтэй холбогдуулан төрийн захиргааны байгууллагаас ямар арга хэмжээ авч байгаа талаар,

Энэхүү асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд яаралтай горимоор танилцуулахыг танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Я.САНЖМЯТАВ